

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

№02



Эмхэтгэсэн: Номзүйч С.Найгалмаа

Ж.Оюунчимэг

Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2-3
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3-4
ХӨДӨӨ АЖ АХУЙ. ОЙН АЖ АХУЙ.....	4-5
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	5
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	5-6
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	6-9
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	9-10
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	10-13
СОЁЛ.ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.	13-14
БОЛОВСРОЛ БА СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	14-15
СЭТГҮҮЛ ЗҮЙ.....	15
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	15-16
АМАН ЗОХИОЛ. АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ	17
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	17
УРАН ЗОХИОЛ.....	17-18
УРЛАГ БА УРЛАГ СУДЛАЛ.....	19
ШАШИН СУДЛАЛ.....	19-20
СЭТГЭЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААН	20
НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	21
ГАДААД ХЭЛ ДЭЭРХИ НОМ.....	21-29

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ-Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/
НХУУТ-Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/
ГФ- Гадаад номын фонд /411 тоот/
ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/
ЛавФ- Лавлагааны фонд- /409 тоот/
БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/
ХЗС-Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/
ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын
сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Болормаа О., Буян Ч. **Анализын багажит аргуудын бодлого, дасгал** / Хян. Г.Сүхдорж.- Анхны хэвл.- УБ.: МУИС пресс, 2019.- 150х.- ISBN 978-99978-69-15-9.



Энэхүү ном нь анализын оптик, цахилгаан-химийн, ялган салгах аргууд гэсэн 3 бүлгээс бүрдэх ба бүлэг бүрт онолын товч хэсэг, жишээ бодлогыг тайлбартайгаар оруулж, сэдэв бүрийн дараа бие даан бодох бодлого, өөрийгөө шалгах асуулттай уг гарын авлага нь их сургууль, коллеж, ЕБС-ийн сурагчид, багш нарт зориулжээ.


24.4я7

Б 559

/БУУТ-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-22721-22723

Аналитик химийн дадлагын ажлууд: Чанарын ба тооны анализын аргууд: / О.Болормаа, С.Даваасүрэн, Г.Сүхдорж ба бус.; Хян. С.Даваасүрэн, Г.Сүхдорж, О.Болормаа.- 4 дэх хэвл.- УБ.: МУИС пресс, 2019.- 172х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISBN 978-99978-86-84-28.



Уг гарын авлагад чанарын анализын хагас- микро болоод дуслын аргаар катионуудыг хүчил, шүлтийн, анионуудыг мөнгөний ба барийн давсны уусмалтай харилцан үйлчлэх онцлог шинж чанар дээр үндэслэн ангилсан ангилалыг, мөн анион, катионуудыг эрэмбэт аргыг хэрэглэн адил төстэй шинж чанараар нь бүлэглэн, бүлэг тус бүрийн ионуудын өвөрмөц, онцлог урвалаар ялган танихаар бүдүүвчлэн нэгтгэж оруулсан. Энэхүү гарын авлагыг их, дээд сургуулийн химийн мэргэжлийн ангийн оюутнуудад зориулжээ.

24.4я7

А 591

/БУУТ-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-22724-22726

ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Ган-Очир Ж. **Хагарлын тектоник, хүдэржил** / Ерөн. ред. О.Төмөртоогоо; Ред. Б.Дэлгэрцогт.- УБ.: Линограф.- 141х.



Зохиогч энэ номондоо Монгол орны тодорхой бүс нутгуудын хил залгаа нутгийн тогтоцтой тектоникийн структур, хагарал, ан цавшилтын талаархи өөрийн судалгааны үр дүнг тайлбарласан төдийгүй цаашид ялангуяа ашигт малтмалын эрлийн судалгаа хийхдээ тектоник, хагарал, эвдрэлийн процессд анхаарах хэрэгтэйг онцлоод, сансрын зургийн тайлал хийх, геохими, геофизик, геологийн зураглалын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэх чухал санаануудыг дэвшүүлжээ.


26.324

Г 21

ЭШФ Б-29249-29251

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баасанжав Г., Цэнд-Аюуш Я. **Монгол орны загас.-** 2 дахь хэвл.- УБ.: Адмон ХХК., 2018.- 176х.- ISBN 978-99978-3-832-2.



Тус номонд монгол орны загас судлалын товч түүх, загасны зүйлийн бүрэлдэхүүн, гарал үүсэл, загасны аймгийн иж бүрдэл, загасны ховордолын үнэлгээ, загас агнуурын талаар өгүүлсэн байна. Энэ хоёр дахь хэвлэлтийн агуулгын онцлог нь загасны зарим нэршил ба хамгаалалтын үнэлгээг дэлхийн болон бүс нутгийн улаан дансны ангилалын шалгуураар үнэлж, нэрлэсний дагуу засахын зэрэгцээ шинээр бүртгэгдсэн зарим загасыг нэмж, зарим загасны өнгөт зургийг шинэчлэн оруулж, ангилал зүйн судалгааны бүрэн хэмжээсийн үндсэн зарчим, тооцооллын эх загварыг овог, овгоор нь ангилан бичиж, загасны зүйлийн жагсаалтыг 4 хэлээр хавсаргасан байна.

28.693.32(1)

Б 109

/ГНОФ-3ш, БУУТ-5ш/

ЭШФ Т-22717-22718

Баасанжав Г., Цэнд-Аюуш Я. **Загас судлал ба загасны аж ахуй** / Хян. С.Оюунзул, К.Улыкпан.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 100х.- ISBN 99978-3-96 9-2.



Энэ монографи бүтээлд судлаачид усан орчны экологи нөхцөл, загасны амьдралд усны шим ба шим бус хүчин зүйлсийн үзүүлэх нөлөө холбогдлыг дэлгэрэнгүй тусгаж, загасны биеийн бүтэц, физиологийн онцлог, үржил бойжлын нөхцөл зэрэг хамгийн гол ухагдахууныг багтааснаас гадна загасны хөврөлийн хөгжил, бойжил, өсөлтийг судлах аргууд болон манай орны нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой цөөрмийн аж ахуйг байгуулж, загас үржүүлэх хялбар дөхөм аргуудын талаар олон жилийн судалгаандаа үндэслэн энгийн ойлгомжтой өгүүлжээ.

28.693.32

/ГНОФ-3ш, БУУТ-5ш/

ЭШФ Т-22719-22720

Б 109

Усних Г., Баттогтох Д. **Проект дүрслэл: ШУТИС-ийн оюутанд зориулсан гарын авлага** / Ред. Ш.Цэвээндорж, Н.Доржбалдан.- 15 дахь хэвл.- УБ.: Линограф, 2019.- 56х.



Энэхүү гарын авлагад проекц дүрслэл, аксонометр проекцийн тухай ерөнхий ойлголт, проекцийн байдал, зүсэлт, огтлол, томруулсан элемент, дүрслэлд хэрэглэх хялбарчлал ба томъёолол, материалын график тэмдэглэгээ, тойргийн аксонометр байгуулах аргачлал болон тухайн сэдвийн дагуу хийх бие даалтын ажлыг хавсарган оруулсан байна.

30.11

Б 341

/БУУТ- 5ш, ГНОФ- 12ш/

ЭШФ Б-29258-29260

Баттогтох Д., Дамчаасүрэн Х. **Геометр байгуулалт: Их, дээд сургууль, коллежийн оюутанд зориулсан гарын авлага** / Ред. Ц.Дагвадорж.- 20 дахь хэвл.- УБ.: Линограф, 2018.- 60х.



Тус гарын авлагад параллель, перпендикуляр шулуун татах, хэрчим, өнцөг, тойрог хуваах, радиус тодорхойлох, нум зурах, олон өнцөгт байгуулах, гортигийн ба лекалын муруй гэх мэт геометр байгуулалтын

элементүүд болон техникийн зургийн гүйцэтгэлийн үндсэн дүрэм, сэдвийн хүрээнд хийх бие даалтыг хамтатган багтаажээ.

30.11

Б 341

/БУУТ- 5ш, ГНОФ- 7ш/

ЭШФ Б-29255-29257

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Дэлхийн радио холбооны дүрэм бүлэг: Боть-1.- УБ., 2016.- 304х.- ISBN 978-99978-4-593- 1.

Тус цувралд радио холбооны нийтлэг нэр томъёо, радио давтамж, радио үйлчилгээний болон тодорхойлолт, онцгой байдал, аюулгүй байдлын харилцаа холбоо, нисэх онгоцны үйлчилгээний процедур, дүрэм, заалт, ОУ-ын конвенцийг оруулсан.



32.88

Д 893

/ БУУТ-3ш/

ЭШФ Б-29220-29222

Дэлхийн радио холбооны дүрэм хавсралтууд: Боть-2.- УБ., 2016.- 648х.- ISBN 978- 99978-4-593-1.

Тус цувралд радио долгионы цацаргалтын ангилал, цагаан толгойн үсгийн дуудлага болон дүрс код, хиймэл дагуул, газрын станцтай холбоотой тэмдэглэлүүд өгөгдөх үндсэн характеристикүүд болон олон улсын дуудлагын тэмдгийн цувааны хүснэгтийг багтаасан байна.



32.88


Д 893

/БУУТ-3ш/

ЭШФ Б-29223-29225

Дэлхийн радио холбооны дүрэм тогтоолууд: Боть-3.- УБ., 2016.- 294х.- ISBN 978-99978-4-593-1.

Тус цувралд радио давтамжийн менежментийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, газрын станц, геостационар, радионавигац ба цаг уурын хиймэл дагуулын сүлжээ, төмөр зам, нисэх онгоцны хөдөлгөөнт үйлчилгээ зэрэг радио холбооны бүхий л үйл ажиллагааг зохицуулах дүрэм тогтоолууд, Дэлхийн Радио Холбооны их хуралд 2019 онд, 2023 онд хэлэлцэх асуудлууд орсон байна.



32.88


Д 893

/БУУТ-3ш/

ЭШФ Б-29226-29228

Алимаа В. Газрын тосны салбарын монгол-англи-орос толь=Mongolian-english- russian petroleum dictionary=Монголо-англо-русский словарь нефтегазовой отрасли / Хян. Ц.Алтанцэцэг., М.Түвшин.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2019.- 341х.- ISBN 978-99929-51-91-5.

Газрын тосны салбарын бүхий л мэргэжлийн нийтлэг нэр томъёо, үг хэллэгүүдийг иж бүрнээр нь тусгахыг зорьж бүтээсэн энэхүү толь бичгийг монгол-англи-орос хэлээр эмхэтгэн уншигч танаа хүргэж байна.



35.514я2

А 466

/БУУТ-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22730-22732

Алимаа В., Цэвээнжав Ж. Газрын тосны бүтээгдэхүүнүүд ба орлох түлш, шатахуун=**Petroleum products and alternative fuels**: Сурах бичиг / Хян. Ц.Багмид, Ж.Цэвээнжав, Д.Эрдэнчимэг.- 4 дэх хэвл.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2018.- 301х.- (ШУТИС. Геологи, уул уурхайн сургууль).- ISBN 978-99929-3-069-1.



Энэ номонд газрын тосны бүтээгдэхүүнүүд, хөдөлгүүрийн түлш, тос болон тосолгооны материалын нэр төрөл, ангилал, физик-химийн болон ашиглалтын экологийн шинж чанар, хэрэглээний онцлог мөн альтернатив түлш, шатахууны нэр төрөл, шинж чанар, газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлын нормчлолын асуудал, удаан хугацаагаар хадгалах бүтээгдэхүүний чанарт тавигдах шаардлага зэрэг агуулгыг хамарсан байна. Энэ сурах бичгийг мэргэжлийн салбарын суралцагсад, мэргэжилтэн, судлаач, сонирхогч нарт зориулан гаргажээ.

35.514я73

А 466

/БУУТ-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22727-22729

Дашбал С. **Арьс, шир боловсруулах технологийн судалгаа хөгжил**: Арьс, шир боловсруулах технологийн шинэчлэлд / Хян. М.Мөнхбат.- УБ.: Содпресс, 2019.- 250х.- ISBN 978-9919-21-097-7.



Энэхүү бүтээлд арьс ширийг боловсруулахад ашигладаг хром болон хүнд металл агуулсан химийн материалын хэрэглээг бууруулах, цаашид хязгаарлах төдийгүй “органик буюу эко савхи” гарган авах чиг хандлага руу явахыг дэлхийн арьс ширний холбооноос зөвлөж байгаа өнөө цаг үед манай улс ч бас боловсруулах технологио шинэчлэх, энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэйг онцлоод, олон улсад “ногоон” технологээр боловсруулах талаар хийсэн судалгаанууд, арьс ширний бүтэц, бүрэлдэхүүн, боловсруулалтын явц, экологийн асуудлуудын талаар тодорхой тайлбарласан байна.

37.252

Д 392

ЭШФ Б-29296-29297

ХӨДӨӨ АЖ АХУЙ. ОЙН АЖ АХУЙ

Аваадорж Д. **Хөрс судлал** / Ред. Б.Одгэрэл.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2019.- 498х.- (Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам).



Зохиогч энэ номондоо хөрсний гарал үүсэл, тэнд явагдах гол үйл явцыг нэг талаас эко системтэй, нөгөө талаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй холбож тайлбарлаад, мөн түүний хүрээлэн буй орчин, эко системд гүйцэтгэх үүрэг ач холбогдлын талаар илүүтэй авч үзсэн төдийгүй өмнөх хэвлэлээс агуулгын хувьд сайжирч, мэргэжлийн утга санаа, үг хэллэгийг энгийн хялбар, ойлгомжтой болгосон байна.


40.3я73

А 152

/БУУТ-3ш/

ЭШФ Т-22733-22734

Надмид Н. **Ямааны аж ахуй** / Ред. А.Бат-Эрдэнэ.- УБ.: Адмон, 2019.- 300х.- ISBN 978-99978-67-43-8.- (ХААИС. МАА, Биотехнологийн сургууль).



Энэ номонд дэлхийн ямааны тоо, ашиг шимийн чиглэл, МУ-ын ямааны аж ахуйн хөгжилт, тоо, байршил, тулгамдсан асуудал, зорилт, ямааны гарал үүсэл, хувьсал, зэрлэг удмууд, ямааны үүлдрийн ангилал, биологи онцлог, бие цогцос, галбир, интерьер, арьс үсэн бүрхүүлийн шинж чанар, арьсны бичил бүтэц, үсний уутанцрын хөгжилт, ноос ноолуурын бүтэц, физик, хими, механик шинж чанар, ашиг шим, тэдгээрийг сайжруулах арга зам, сүү, мах, арьсны таваарын шинж чанар, стандарт, удам зүйн үндэс, хээлтүүлэг, эмчилгээ, маллагааны арга туршлага гэх мэт ямааны аж ахуйтай холбоотой бүхий л мэдээллийг багтаасан байна.

46.6

Н 166

ЭШФ Т-22697-22698

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Социологи / Англи хэлнээс орч. Д. Мөнхтөр, Ц. Болд, Д. Бадамдаш ба бус.; Ред. С.Ууганбаяр, С.Ганбат, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2018.- 352х.- ISBN 978-99973-1-566-3.



Тухайн бүтээлд социологийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, ойлголтыг энгийн үг хэллэгээр тайлбарлаж, дэлгэрүүлэн унших гол бүтээлүүдийг танилцуулсан байна. Тухайлбал: Нийгмийн бүлгүүд үндсээрээ устах болов уу, Хүн яагаад гэмт хэргийн ертөнц руу татагддаг вэ, Интернэт бидний харилцааг хэрхэн өөрчлөв, эрт эдүгээгээс хойш хүн төрөлхтөн өөрсдийн нийгмийг хэрхэн зохион байгуулж буй талаар олон асуултуудыг хүн төрөлхтөн тавьсаар ирсэн бөгөөд социологчид үүний хариултыг олж хариулан, дэлхий ертөнцөө улам төгөлдөржүүлсээр ирсэн тухай өгүүлээд, мэргэжлийн үг хэллэг, ойлгомжгүй онолуудыг задлан тайлбарлажээ.

60.5

С 61

/НХУУТ-7ш/

ЭШФ Т-22766-22768

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Гэр харуулын түүхэнд холбогдох архивын баримтууд-I: Халхын Сайн ноён аймгийн гэр харуул / Эмхт. Э.Жигмэддорж, Г.Намнансүрэн; Ред. П.Дэлгэржаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 239х.- (Архивын ерөнхий газар. МУИС-ийн түүхийн тэнхим. Хөвсгөл аймгийн Хатгалын нутгийн зөвлөл).- ISBN 978-99978-791-1-0.



Энэ баримт бичгийн эмхэтгэлд МУ-ын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй XVIII-XX зууны эхэн үед Монгол нутгийн умард хил хязгаарыг сахин хамгаалж байсан Гэр харуулынхны түүхэнд холбогдох данс хараа, газрын зураг, дүрэм журмаас тоймлон оруулсан болно.


63.3(1)5

Г 94

/НХУУТ-4ш/

ЭШФ Т-22751-22754

Жамбал А. Түүхч эрдэмтэн Абилтайн Минис: Амьдрал үйлс, бүтээл туурвилын тойм / Ред. Г.Наранбаяр.- УБ.: Китаб, 2019.- 78х.- ISBN 978-99978-67-44-5.



Тухайн үеийн нэрээр МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн институтэд ажиллаж байсан нэрт эрдэмтдийн намтар, бүтээл туурвил

болон тус институтын улс орны хөгжилд оруулсан хувь нэмрийг судлан тэмдэглэсэн ном бүтээлийг цувралаар гаргаж олны хүртээл болгох зорилгын хүрээнд хэвлүүлсэн энэ товхимолд түүхч эрдэмтэн А. Минисийн намтар, амьдрал, үйл ажиллагаа, бүтээл туурвилыг архивын баримт материалд үндэслэн бэлтгэж, эрдэмтний 90 насны ойд зориулан гаргажээ.

63.3(1)

Ж 231

ЭШФ Б-29301-29302

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Монгол Улсын санхүүгийн албаны түүх (1911-1921): I / Боловс. З. Лонжид; Зөвл. О.Батсайхан; Хян. Д.Махвал.- УБ., 2006.- 120х.- (Монгол Улсын Сангийн яам. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтны холбоо. Монгол Улсын Их Сургууль).



Энэхүү товхимлын гол агуулга нь 1911 оноос 1921 оны 7-аар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаа буюу Хаант Монгол Улс, Автономит Гадаад Монгол Улс, Р.Ш.Унгерний сэргээсэн Монгол улсын төрөөс тус орны санхүү, төсөв, эдийн засаг, аж ахуйн талаар баримталж байсан бодлого, түүний агуулга, хэрэгжилт, үр дүнг нэхэн тодруулахад оршиж байна.

65.02

М-69

/БС-2ш/

ЭШФ Б-29232-29234

Хаадын сангаас хөгжлийн сан: Сангийн яам байгуулагдсаны 100 жилийн ойд өргөн барив / Эмхт. Б.Одонбилэг; Ерөн. ред. Д.Цогтбаатар; Хян. Р.Гансүх.- УБ.: Х-Press, 2011.- 211х.- (Сангийн яам).



Сангийн яамны 100 жилийн ойд зориулан энэхүү түүхэн товчоог бүтээжээ. Үндэсний эрх чөлөөний төлөөх тэмцлийн хүнд бэрх цаг үеэс эхэлсэн санхүүгийн албаны түүх нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн он жилүүд, зах зээлийн эдийн засгийн шинэ харилцааг бэхжүүлэх, дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал зэрэг амаргүй давааг туулж, эх орныхоо хөгжил дэвшлийн ундарга байсаар ирсэн түүхэн гавъяа, бүтээлч үйлсийн замналыг харуулжээ.

65.261(1)

Х-107

/БС-2ш/

ЭШФ Б-29241-29242

Монгол Улсын Сангийн яам 2006 онд: Эх түүх / Эрхл. Ц. Батнасан, Д.Баасанжав; Хян. Ж.Жаргалсайхан, Д.Цогтбаатар.- УБ.: Хөх судар, 2007.- 142х.



Монгол улсын Сангийн яамны эх түүхийг эмхэтгэн цувралаар гаргаж буй энэ товхимолд Сангийн яамны 2006 оны үйл ажиллагааг тайлагнахдаа Монгол Улсын Засгийн газрын бодлого чиглэл, улс орны дотоод, гадаад бодлогын хэрэгжилт, мөнгө санхүүгийн бодлого, хууль ёсыг тодорхой тусгасан байна.

65.261(1)

М-692

/БС-2ш/

ЭШФ Б-29246-29248

Монгол Улсын Сангийн яам 2005 онд: Эх түүх / Эрхл. Ц.Батнасан, Д.Баасанжав; Хян. Д.Цогтбаатар.- УБ.: Хөх судар, 2008.- 224х.



Монгол улсын Сангийн яамны эх түүхийг эмхэтгэн цувралаар гаргаж буй энэ товхимолд Сангийн яамны 2005 оны үйл ажиллагааг тайлагнахдаа Монгол Улсын Засгийн газрын бодлого чиглэл, улс орны дотоод, гадаад бодлогын хэрэгжилт, мөнгө санхүүгийн бодлого, хууль ёсыг тодорхой тусгасан байна.

65.261(1)

М-692

/БС-2ш/

ЭШФ Б-29243-29245

Монгол банкны захиргааны хэм хэмжээний акт: Эмхэтгэл-I.- УБ., 2019.- 394х.



Энэхүү эмхэтгэлд ня-бо бүртгэл, цахим мөнгө, банкиг албадан татан буулгах, банкны бүтцийн өөрчлөлт хийх, банкны үйл ажиллагаанд хязгаарлалт тавих болон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гэх мэт үйл ажиллагааны хэм хэмжээг зохицуулах эрх зүйн актуудыг багтаасан байна.

65.262(1)

М 692

/БС- 2ш/

ЭШФ Т-22674-22675

Клайн Наоми. **Шок номлол=The shock doctrine:** Гамшгийн капитализмын үүсэл=The rise of disaster / Орч. О.Гомбожав, С.Ганбат; Орч. ред. Г.Халиунаа; Хян. С.Ууганбаяр, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2018.- 700х.- ISBN 978-99973-1-735-3.



Бидний мэдэх “чөлөөт зах зээл” гэгчийн үнэн төрхийг илчилж, бидний эдийн засгийг чухам ямар хүч хөдөлгөж буйг таниулсан энэ гайхамшигтай бүтээлд улс төрийн махны машин эдийн засгийн бодлогыг хүчээр хэрэгжүүлж, эсэргүүцсэн улс орон, хүн ардыг хэрхэн нухчин дардагийн том жишээ болсон 1973 оны Чили улсын түүхээс эхэлж, өнөөгийн Ирак улс хүртэл улс төрийн радикал бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Фридман болон түүний шавь нар аймшигт шок хүчирхийллийг удаа дараа хэрэгжүүлж байгааг Клайн энэ номондоо яруу тодоор дүрслэн харуулжээ.

65.01

К 47

ЭШФ Б-29307-29309

Нарантуяа Д., Ариунаа Ж. **Мерчандайзинг:** Дэд дэвтэр: Борлуулалт & категорийн удирдлага / Ред. М.Должин.- УБ.: Алмаз пресс, 2018.- 176х.- ISBN 978-99973-3-927-0.



Барааны ангилал нэр төрөл, худалдааны газрын байршил, барааг үр ашигтай борлуулах арга, бөөний худалдааны хөгжил болон бараа бүтээгдэхүүнд тавих хяналт бүртгэлийн талаар дэлгэрэнгүй тайлбарласан энэ номыг зохиогчид олон жилийн сургалт судалгааны үр дүн, ажлын туршлага дээрээ тулгуурлан бүтээжээ.

65.422

Н 294

/НХУУТ-3ш/

ЭШФ Т-22764-22765

Квинт В.Л. **Стратеги боловсруулах концепц** / Орч. Б.Болормаа; Орч. хян. О.Базар.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх, 2019.- 120х.- ISBN 978-99978-67-90-2.



Номонд стратегийн онолын хөгжлийн тухай ойлголт, хэрхэн стратегич сэтгэлгээгээр стратеги боловсруулах, бодитоор хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, хөгжүүлэх зэрэг үе шатуудад зайлшгүй шаардлагатай онол практикийн ач холбогдолтой агуулгыг нэгтгэсэн цогц ойлголтыг багтаажээ.

65.290-2

К 327

/НХУУТ-2ш/

ЭШФ Б-29303-29304

Монгол банк жилийн тайлан 2018.- УБ., 2017.- 210х.

Энэхүү эмхэтгэлд мөнгөний бодлого, инфляци, улсын нэгдсэн төсөв, үнэт цаас, валютын худалдаа болон санхүүгийн тайлан, статистик тойм зэрэг МУ-ын эдийн засагт бий болсон ахиу өөрчлөлтийн тайланг толилуулж байна.

65.262.1(1)

М 692

ЭШФ 22 348-349




Мөнгө, санхүү, баялаг=Money, finance, wealth: Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл 2019. №12.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 132х.- ISSN 2521-1501.

Энэхүү судалгааны сэтгүүлд "Эдийн засгийн бодлогын чуулган-2019"-ийг нээж МУ-ын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын хэлсэн үг, болон "Санхүүгийн салбарын хөгжил: Өнгөрсөн, одоо, ирээдүй" эрдэм шинжилгээний хурлыг нээж Монгол банкны ерөнхийлөгч Н.Баяртсайханы хэлсэн үг, Монгол улсын эдийн засаг, банкны салбарын хөгжил 95 жилд: ололт, сорилт, сургамж, Финтекийн хөгжил, эрх зүйн зохицуулалт, Орон нутагт арилжааны банкны гүйцэтгэх үүрэг, Эдийн засгийн өсөлтийг хангах инфляцийн төлөв байдлыг шинжих асуудалд, Нэрлэсэн ханшийн зохистой түвшин, Экспортын голлох түүхий эдийн үнийн хандлагын асуудалд зэрэг судалгаа шинжилгээний өгүүлэлүүд оржээ.

65

М 811

ЭШФ 22 350-351



Мөнгө, санхүү, баялаг=Money, finance, wealth: Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл 2019. №13.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 132х.- ISSN 2521-1501.

Энэхүү судалгааны сэтгүүлд Монгол банкны үйл ажиллагааны тайлан, Валютын зах дахь Төв банкны оролцоо: интервенцийн асуудал, Central banking in the digital age: a new money, Евразийн эдийн засгийн холбооны хүрээлэнд хамтын ажиллагааг хөгжүүлэх Монгол Улсын боломж, Үндэсний тогтолцооны системийн хөгжил, өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал, Нөөц, ашиглалтын хүснэгтийн дүнгээр үндэсний тогтолцооны үзүүлэлтийг шинэчлэн



тооцох, Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон имфляцийн түвшний 2019-2025 оны таамаглал зэрэг судалгаа шинжилгээний өгүүлэлүүд оржээ.

65

М 811

ЭШФ 22 352-353

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Рассел Б. **Эрх мэдэл: Нийгмийн шинэ дүн шинжилгээ** / Орч. Р.Батмэнд; Хян. Б.Даш-Ёндон.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 372х.- ISBN 978-99978-66-39-4.



Энэ номонд зохиолч “хүн ба амьтны оюун санааны, сэтгэл хөөрлийн онцлог ялгааг тодорхойлж, хүмүүний хүсэл эрмэлзлэл нь хэмжээ хязгааргүй байх атлаа тэрээр сэтгэлийн ханамжаа бүрэн гүйцэлдүүлэх чадваргүй байдаг, хүн бол хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн үйлдэж, хөдөлдөг нийгмийн амьтан гэдгийг тод томруун тайлбарлажээ.

66

Р 244

/ОУХНУС-5ш, НХУУТ-3ш/

ЭШФ Б-29263-29264

Монгол улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд= Issues in Mongolian foreign policy and diplomacy: Өгүүллийн эмхэтгэл / Эмхт. С.Баттулга, Ж.Баттөр.- УБ.: Удам соёл, 2019.- 306х.- (МУИС. ОУХНУС).



Уг хамтын бүтээлд “Орчин үеийн Монгол улсын гадаад бодлого, дипломат ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцсэн асуудлыг багцлан нягталж оруулахдаа МУ-ын гадаад бодлого, дипломат харилцаанд үүсэж буй шинэ нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг судлаачийн байр сууринаас задлан шинжилж улмаар хоёрдогч болон гуравдагч хөрш орнууд, бүс нутгийн улсуудтай тогтоосон гадаад харилцаанд цаашид баримтлах бодлого чиглэлийг тодорхойлохыг зорьжээ.

66.4(1)

М 692

/НХУУТ-2ш, ОУХНУС-5ш/

ЭШФ Т-22775-22777

Хантингтон С.П. **Иргэншил хоорондын мөргөлдөөн ба шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам** / Орч. А.Энхбаатар; Ред. С.Ууганбаяр, Орч. ред. С. Ганбат.- УБ.: Монсудар, 2018.- 440х.- ISBN 978-999731-407-9.



Зохиогч энэ номондоо иргэншлийн үзэл баримтлал, универсал иргэншлийн асуудал, засаглал болон соёлын харилцан үйлчлэлийн тухай, иргэншлүүдийн хоорондох засаглалын тэнцвэр өөрчлөгдөх тухай, өрнийн бус нийгмүүдийн соёлын гарвал, өрнөдийн универсализм, исламын дайнч жөтөөрхөл, Хятадын мөчөөрхөл зэргээс үүдэлтэй сөргөлдөөний тухай, Хятадын сүр хүч өсөн нэмэгдэж буйн хариу тактик, “зааг шугамын дагуух дайн тулааны шалтгаан болон өрнөлийн тухай, өрнөдийн болон дэлхийн иргэншлүүдийн хэтийн төлөвийн тухай авч үзсэн нь энэхүү бүтээлээрээ хүйтэн дайны дараах даяаршлын бодлогыг шүүн тунгаахыг зорьжээ.

66.4(0)

Х 226

/НХУУТ-7ш/

ЭШФ Т-22772-22774

Мишель, Обама. **Becoming: Миний түүх** / Ред. Ц.Оюумаа, Ж.Хишигжаргал; Орч. А.Оюунзул; Орч. ред. Н.Жавхлан.- УБ.: Монсудар, 2019.- 480х.- ISBN 978-99973-1-706-3.



АНУ-ын тэргүүн хатагтай асан Мишель Обама Чикагогийн Саут сайдад өнгөрүүлсэн хүүхэд нас, эх хүн, ажил мэргэжлийн хариуцлагаа дэнсэлсэн удирдах албан тушаалын он жилүүд, дэлхийн хамгийн алдартай нэр хаяг бүхий ордонд аж төрсөн үе гээд өөрчлөлт авчирсан амьдралын хором бүрээ үнэн шударгаар, хөгжүүн ухаалгаар, өөрийн бодлоор, өөрийн үгээр ний нуугүй өгүүлж, тод томруун дүрслэн буулгасан энэхүү номоороо дамжуулан уншигч таныг өөрийн ертөнцдөө аялахыг урьжээ.

66.3(7АНУ)8

М 65

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22769-22771

ТӨР ЭРХ. ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Судалгааны эмхэтгэл: Боть XXVIII / Хян. Б.Эрдэнэбилэгт, Ц.Норовдондог; Эмхт. Д.Жигваангүнсэл.- УБ.: УИХ-ын Тамгын газрын хэвлэх, 2019.- 509х.- ISBN 978-99978-915-4-6.- (Улсын Их Хурлын Тамгын Газар. Мэдээлэл, Хяналт, Шинжилгээ, Үнэлгээний Хэлтэс).



УИХ-ын Тамгын Газраас эрхлэн гаргадаг цуврал эмхэтгэлийн энэ дугаарт эдийн засаг, нийгэм, эрх зүй, төрийн байгуулалын хүрээнд гадаад орнуудын туршлага, эрх зүйн орчин, үйл ажиллагааны зохицуулалтын талаар харьцуулан судалсан судалгааны материалуудыг оруулжээ.

67.0+65.9(1)

С-701

/ХЗС 21175-21176/

ЭШФ Т-22699-22700

Төрийн удирдлага: Их сургуулийн үндсэн сурах бичиг / Б.Долгор, Д.Одмаа, Я.Төгөлдөр ба бус.; Ерөн. ред. Б.Долгор, А.Болормаа; Ред. А.Энхбаатар.- УБ.: ШУТИС-ийн хэвлэлийн газар, 2019.- 459х.- (Шинжлэх ухаан, технологийн их сургууль).- ISBN 978-99978-57-72-9.



ШУТИС-ийн 60 жил, тус сургуульд “Төрийн удирдлага” мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэсний 20 жилийн хүрээнд эрдэмтэн багш нарын боловсруулан олны хүртээл болгож буй энэхүү сурах бичиг нь оюутан суралцагчдад шинэ мэдлэг өгөх, сургалтын онол-практикийн уялдааг хангах, ажлын байран дээрээ хөгжих, мэдлэгээ хэрэглээ болгоход нь туслахад чиглэгдсэн хамтын бүтээл болно.

67.400.6я73

Т 594

/ОУХНУС-10 ш/

ЭШФ Т-22714-22716

ХБНГУ-ын арилжааны (худалдааны) хууль / Орч. Б.Буянхишиг.- Анхны хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 331х.- ISBN 978-99978-4-738-6.- (МУИС. Хувийн эрх зүйн тэнхим).



Дэлхийн олон улс орны орчин үеийн Арилжааны хууль тогтоомжийн жишиг болсоор байгаа ХБНГУ-ын Арилжааны хууль, бусад холбогдох

хуулийн хэсэг, түүний агуулга, эрх зүйн хэм хэмжээний хувилбарыг бид энэхүү хуулиас мэдэж болно.

67.404(4Гер)

Х 425

ХЗС 21170-21174

Должин С. **Хувийн эрх зүйн тайлбар толь бичиг** / Э.Байгал, Б.Улаанбаатар.- УБ., 2019.- 240х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISBN 978-99978-126-3.



Хувийн эрх зүйн олон эх сурвалжид нэр томъёоны тодорхойлолт, утга агуулгыг янз бүрээр тодорхойлсон нь эдгээр нэр томъёог ялгаж ойлгоход хуульчид төдийгүй мэргэжлийн бус иргэдэд ч ойлгоход хүндрэлтэй байгаа билээ. Энэ цаг үед хувийн эрх зүйн салбарын эх сурвалжийн тогтолцоонд гарсан өөрчлөлтийг тусгасан эх сурвалжуудын нэр томъёоны олон салаа утгыг цэгцэлсэн бүтээлийг та бүхэнд толилуулж байна. Энэхүү бүтээлийн нэг эх сурвалж нь Монгол Улсын ШУА-ийн академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” хэмээх бүтээл юм.

67.404

Д 473

/ХЗС-10ш, НХУУТ-3ш/

ЭШФ Т-22712-22713

Должин С. **Монгол улсын арбитрын процессын эрх зүй**: Их, дээд сургуулийн хуулийн ангийн оюутнууд болон эрх зүйч, судлаач нарт зориулав.- Анхны хэвл.- УБ., 2017.- 169х.- (МУИС. ХЗС).- ISBN 978-99978-0-874-5.



Орчин үед дэлхий нийтэд улс хоорондын эдийн засгийн харилцаа нь зөвхөн иргэд, иргэд-хуулийн этгээдийн хоорондын хүрээнээс хальж улс-улс хоорондын харилцаа өргөжин хөгжснөөр цаашид хөрөнгө оруулалтын маргаан ихээр гарах хандлага бий болж байгаа энэ цаг үед зохиолч өөрийн эрдэм судалгааны ажилдаа тулгуурлан МУ-д орчин үеийн чиг хандлагатай хөгжиж буй эрх зүйн салбарын эх сурвалжийн тогтолцоонд гарсан өөрчлөлтийг энэхүү сурах бичигтээ тусгасан байна.

67.410(1)

Д 473

ХЗС 93 21250-21264

Гангабаатар Д. **Үндсэн хуулийн эрх зүй**: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал / Ред. Д.Мөнгөндалай.- УБ.: МУИС пресс, 2019.- 311х.- (МУИС. ХЗС).- ISBN 978-99973-42-78-2.



Үндсэн хуулийн эрх зүйг судлахын тулд үндсэн хуульт ёсны онол, зарчмын үндсээс эхлэн судлах шаардлага үүсдэг учраас зохиогч энэ номондоо үндсэн хуулийн тухай ойлголт, үндсэн хуулийн хөгжил, бүтэц, эх сурвалж, ангилал, эрх зүйн зарчмууд, МУ-ын бүрэн эрхт байдал, засаг захиргаа, төрийн эрх мэдэл, төрийн байгууламж, гүйцэтгэх эрх мэдэл болон шүүх эрх мэдэлийн зарчмуудын талаар эрдэмтэн судлаачдын бүтээл туурвилд түшиглэн бүтээсэн сурах бичгийг хуулийн оюутны сургалт, судалгааны хэрэгцээнд зориулан гаргажээ.

67.400.1

Г 215

ХЗС 93 21265-21274

Батболд Д. **Нийтийн эрх зүй дэх тулгамдсан асуудал** / Ред. Д.Солонго.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 236х.- (МУИС. ХЗС).- ISBN 978-99973-976-9-0.

Зохиогч энэ номондоо нийтийн эрх зүй дэх тулгамдсан асуудлыг Үндсэн хууль, захиргааны эрх зүй, нийтийн албаны эрх зүй, эрдэс баялагийн ба орон нутгийн эрх зүйн зангилаа асуудлын хүрээнд тодорхой сэдвүүдээр авч үзсэн төдийгүй мөн захиргааны эрх зүйн хэсэгт нэмэлт сайжруулалт оруулсан хоёр дахь хэвлэлээ хууль зүйн салбарын сургалт, судалгааны хэрэгцээнд зориулан гаргасан байна.

67.4

Б 332



ХЗС 93 21224-21229

Буянхишиг Б. **Иргэний эрх зүйн бодлогын хураамж**: Нийт 30 бодлого, 15 тохиолдол хувилбарын хамт / Хян. А.Дугармаа.- УБ.: LIA Publ, 2018.- 211х.- ISBN 978-99978-3-207-8.

Иргэний эрх зүйн хэрэглээ хичээлийн хүрээнд Иргэний хууль, ИХШХШТХ-ийг хослуулан хэрэглэх дасгал бэлтгэх зорилгоор зохиолч өөрийн олон жилийн судалгаа, сургалтын материал, туршлага дээрээ үндэслэн иргэний процесс болон материаллаг эрх зүйн кэйс, тохиолдлыг цуглуулан эмхэтгэсэн энэ гарын авлагадаа иргэний процессын түгээмэл асуудлыг жишээн дээр авч үзэж, УДШ-ийн ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарыг ашиглахын зэрэгцээ процессын онолын хүрээнд өөрийн багш нарын бүтээлээс тусгажээ.

67.404

Б 81



ХЗС 93 21230-21249

Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг зохицуулах хууль, тогтоомж, дүрэм, журмын эмхтгэл / Эмхт. Р.Батжаргал.- УБ., 2010.- 79х.- (Сангийн яам. Засаглалыг дэмжих төсөл).


Энэхүү эмхэтгэлд Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Монгол Улсын зарим хуульд хөрөнгийг үнэлэх тухай тусгасан заалтууд, холбогдох Засгийн газрын тогтоол, журам, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн дүрэм зэргийг багтаажээ.

67.404.1(1)

Х-608

/НХУУТ-5ш, ГНОФ-3ш, БС-5ш/

ЭШФ Б-29238-29240



Эрх зүй=NUM law review: Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл: 2018. №1. Цуврал 41.- УБ.: МУИС пресс, 2018.- 239х.

Сэтгүүлийн энэ дугаарт 13-р зууны үеийн монголчуудын "Их ёс", Монгол улсын орон нутгийн өмчийн харилцаан дахь тулгамдсан асуудал, улс төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, эрх хасах ялын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, шүүхийн практик, хууль зүйн клиник: пробоно-асуудал шийдэл, татвар төлөвлөлт ба хяналт шалгалтын эрх зүйн үндэс, бичил уурхайн Үндсэн хуулийн хамгаалалт, эрдэс баялаг өмчлөл, ашиглалтын



талаарх Монгол улсын үндсэн хуулийн үзэл баримтлал ба эрдэс баялгийн хууль тогтоомжийн тогтолцоо, ган цөлжилт Монгол болон дэлхийд: Эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх харьяаллын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа зэрэг нийтийн эрх зүй болон хувийн эрх зүйн чиглэлийн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүд оржээ.

67.0(1)

Э 81

ХЗС 93 21287-21291

Эрх зүй=NUM law review: Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл: 2017. №3. Цуврал 39.- УБ.: МУИС пресс, 2017.- 229х.



Эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт Монгол улсын үндсэн хуулийг өөрчлөх асуудлаархи анхдугаар зөвлөлдөх санал асуулга хүчинтэй юу?, Захиргааны акт илт хууль бус болох үндэслэлд эфиденцийн онолыг хэрэглэх үү?, Монгол улсын татварын эрх зүйн түүхэн хөгжил /1924-1992/, Олон улсын шилжих хөдөлгөөний талаар гадаад орнуудын төрөөс баримталж буй бодлогын чиг хандлага ба Монгол улс, Худалдааны эрх зүйг иргэний эрх зүйгээс зааглах онолууд кодификацын асуудал болох нь, Харилцах дансны үлдэгдэлд төлдөг хүүг хязгаарлах замаар зээлийн хүүг бууруулах эрх зүйн зохицуулалт, Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтаас үүсэх эрсдлийн онол, практик зэрэг сэдэв бүхий илтгэл өгүүлэлүүд оржээ.

67.0(1)

Э-81

ХЗС 93 21277-21281

Эрх зүй=NUM law review: Онол, практик, арга зүйн мэргэжлийн улирал тутмын сэтгүүл: 2017. №4. Цуврал 40.- УБ.: МУИС пресс, 2017.- 227х.




Эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт 13-р зууны монголчуудын төр: ойлголт, шинж, онцлог, Үндсэн хуулийн соёл: Сайн туршлага ба Монгол, Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Гэмт хэргийн гэхцөл байдлын криминалистикийн шинжилгээний өнөөгийн чиг хандлага, Барилгын салбар дахь хөдөлмөрийг аюулгүй ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай асуудалд, БНХАУ-ын зохиогчийн эрхийн хамтын удирдлагын байгууллага, Үндсэн хуулийн цэцгийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: Органик хууль ба түүнийг тогтоох эрх зүйн боломж, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолд хийсэн дүн шинжилгээ, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ зэрэг сэдэв бүхий илтгэл өгүүлэлүүд оржээ.

67.0(1)

Э 81

ХЗС 93 21282-21286

Шүүх эрх мэдэл: Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл: 2019 он. №1.- УБ., 2019.- 204х.- ISBN 978-99962-3-728-7.



Тус эмхэтгэлд шүүхийн шийтгэлийн асуудал шинэтгэл, шүүх судлал, шүүхийн шийдвэрийн шинжилгээ гэсэн агуулгын хүрээнд монголын болон гадаадын эрдэмтэн судлаачдын судалгааны өгүүлэлүүд багтсан байна.

67

Ш-978

ХЗС 93 21275-21276

ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

Монгол судлалын чуулган: Эрдэм шинжилгээний сэтгүүл 2019/1. №26(61) / Эрхл. С.Хөвсгөл.- УБ.: Жиком пресс ХХК., 2019.- 227х.- ISSN 2412-9992; ISBN 978-99973-44-52-6.- (МУБИС. Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль).



Сэтгүүлийн энэ дугаарт “Монгол судлалын шинэ эрин-2019” олон улсын эрдэм шинжилгээний хурлын Бүгд болон салбар хуралдаанд тавигдсан монгол хэл, утга зохиол, соёл судлал, түүхийн салбарын судлаачдын илтгэлүүдийг оруулсан байна.

72я5

М 692

ЭШФ Т-22669

Монгол судлалын чуулган: Эрдэм шинжилгээний сэтгүүл 2019/2. №27(62) / Эрхл. С.Хөвсгөл.- УБ.: Жиком пресс ХХК, 2019.- 233х.- ISSN 2412-9992; ISBN 978-99973-44-52-6.- (МУБИС. Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль).



Сэтгүүлийн энэ дугаарт “Монгол судлалын шинэ эрин-2019” олон улсын эрдэм шинжилгээний хурлын салбар хуралдаанд хэл шинжлэл, уран зохиол, аман зохиол судлал, соёл судлал, сэтгүүл зүйн чиглэлээр тавигдсан илтгэлүүдийг эмхэтгэжээ.

72я5

М 692

ЭШФ Т-22670

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Физик / Эмхт. Г.Эрдэнэ-очир.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2019.- 79х.- ISSN 2311-1097.



Сэтгүүлийн энэ дугаарт физикийн салбарын эрдэмтэн судлаачдын 15 судалгааны өгүүлэл, илтгэлүүд оржээ.

72+22.3я5

М 692

/ЛавФ-1ш/

ЭШФ Т-22778-22780

Эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны 2018 оны тайлан / Эмхт. С.Баянсан, Г.Пүрэвдорж, Н.Нарантуяа, Ц.Энхчимэг, Ц.Болортамир, Д.Энх-амгалан; Ред. Б.Авид, С.Баянсан.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 272х.



Уг эмхэтгэлд Монгол улсын Шинжлэх ухааны академийн 2018 оны үйл ажиллагааны зохион байгуулалт, салбар шинжлэх ухааны судалгааны ажлын тайлан, төслийн үр дүнг тайлагнасан байна.

72(1)

Э 73

ЭШФ 22 347

БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН

Алтангэрэл Б. Дээд боловсролын менежмент.- УБ., 2019.- 145х.- (Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль).- ISBN 978-99962-946-4-8.



Энэхүү номонд дээд боловсролын менежментийн уламжлалт болон орчин үеийн онол, загваруудыг харьцуулан авч үзсэн нь практик ач холбогдолтой болжээ. Зохиогч олон улсын байгууллага, улс орнуудын Засгийн газар, мэргэжлийн байгууллагуудын бодлогын баримт бичгүүд, судлаачдын бүтээл дээр тулгуурлан мэдлэгийн эдийн засгийн эрин үед дээд боловсролын хөгжлийн чиг хандлагын талаар тусгасан байна. Түүнчлэн хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын дээд боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа реформ, шинэчлэлийг тодорхой жишээ баримтаар дурджээ.

74.58

А-486

/НХУУТ-7ш/

ЭШФ Б-29265-29267

Баттогтох Д. **Боловсрол судлалын өгүүллүүд** / Ред. Н.Бэгз.- УБ., 2018.- (Боловсролын Шинжлэх Ухааны Академи).- ISBN 978-99978-2-643-5.

Эмхэтгэлд монголын боловсролын түүх, ардын сурган хүмүүжүүлэх ухаан, боловсролын гүн ухаан, боловсролын дидактикийн талаар эрдэмтний олон жил судлан шинжилж, бичсэн сургалт судалгааны нэлээд хэдэн өгүүлэл нь багтсан байна.

74.03

Б 341

/НХУУТ-7ш/

ЭШФ Т-22738-22740



Одмаа Д. **Судалгааны бүтээлийн товчоон**: 1-р дэвт.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх, 2018.- 174х.- ISBN 978-99978-4-873-4.

Тухайн бүтээл нь улс төр судлал, боловсролын удирдлага, олон нийтийн харилцаа (PR), төрийн удирдлага гэсэн үндсэн дөрвөн бүлгийн хүрээнд нийгмийн шинжлэх ухааны онол хандлага, үзэл баримтлал, шинжилгээ судалгааны үр дүн, практик асуудлууд ба танин мэдэхүйн ач холбогдол бүхий агуулгыг хамарсан төдийгүй дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй олон өөрчлөлт, шинэчлэлүүдийн талаар асуудал хөндсөн сургалт судалгааны цогц бүтээл болжээ.

74.58

О 195

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22735-22737



СЭТГҮҮЛ ЗҮЙ

Батцэнгэл Л. **Сэтгэлийн гэрэлт сүмбэрүүд-2** / Ред. Д.Оюунтуяа, Х.Наранхишигт.- УБ.: Артсофт, 2019.- 420х.- ISBN 978-99978-3-036-4.

Сэтгүүлч, яруу найрагч Л.Батцэнгэлийн энэ номонд ардын уран зохиолч, төрийн шагналт яруу найрагчид, уран бүтээлчдийн олон хөрөг, хөөрөлдөөн багтжээ. Тэдний утга төгөлдөр амьдралын намтар хэн бүхний аж төрөлд сургамж, сэтгэлийн таашаал бэлэглэх нь дамжиггүй. Ончтой асуулт, наалдацтай яриагаараа утга зохиолын ертөнцийн сор нь болсон олон сайхан уран бүтээлчдийн дотрыг уудалж, үнэтэй сайхан санаа бодлыг нь гаргуулж аваад, уншигчдад “Оюунаа хоолло” гээд өргөн барьсан байна. Түүний ярилцлагууд нэг талаасаа хөрөг мэт, нөгөө талаасаа мөшгөн нягталсан эрэн сурвалжлахуйн бүтээл болжээ.

76.01

Б-342

/НХУУТ-3ш/

ЭШФ Б-29270-29271



ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Агваандандар. **Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой** / Эрхлэн хэвл. Бу.Мөнхөө, На. Сүхбаатар; Ред. Х.Бямбажав; Хэвлэлд бэлт. А.Батсуурь, Г.Ядамжав.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 229х.- (Баруун хойтын Үндэстний Их Сургууль. МХСДС. Тод номын гэрэл төв).- ISBN 978-99978-2-331-1.



Алашаа Лхарамба Агваандандарын 1838 онд зохиосон “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээх дохионы бичиг оршвой” хэмээх толь бичиг нь одоо Ховд аймгийн Манхан сумын Раашгонзэглин хийдийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Энд толилуулж буй толь бичиг нь түүний “Төвд-Ойрад монгол” хувилбар нь бөгөөд тус хэвлэлд судрын төвд үгийг цахим бичвэрт буулгаж, ойрад үг аялгуут үгчилсэн төвд үсгийг тод үсгээр хөрвүүлэн бичиж, мөн орчин цагийн монгол хэл аялга, кирилл үсгээр хадаж, нэрийн хэлхээг хойно хавсаргасан байна.

81.2М

А 214

/НХУУТ-5ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-29277-29281

Оюун Ц. **Хэл, соёл, сэтгэлгээ: Их, дээд сургуулийн сурах бичиг: Докторант, магистрант, оюутанд зориулав** / Ред. Ж.Батбаатар, Ш.Баттөгс.- УБ.: Хөх монгол принтинг, 2019.- 196х.- (МУБИС. Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль).- ISBN 978-99978-67-50-6.




Энэ ном хэл судлал, соёл судлал, хэл соёлын шүтэн барилдлага, сэтгэлгээ ба сэтгэлгээний хэв маяг, хэл-соёл-сэтгэлгээний холбоо хамаарал гэсэн таван бүлгээс бүрджээ. Зохиогч дээрхи агуулгыг нийгэм хэл шинжлэл, сэтгэл хэл шинжлэл зэрэг олон шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судалсан судалгаа, туршлага мэдлэгтээ тулгуурлан уг бүтээлээ туурвисан байна.

81я73

О 634

ЭШФ Т-22755-22756

Оюунцэцэг Ж. **Англи хэлний зүй: English Grammar** / Хян. Ц.Сумъяа.- 12 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 647х.- (Юниграм гадаад хэлний сургалтын төв. Төрийн удирдлага, засаглалын академи).- ISBN 978-99962-3-762-1.



